

APU COMPANY
Absolute. Pure. Unique.



**ТОГТВОРТОЙ
ХӨГЖИЛ**

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА



**“ ТОГТОЛЦООГООРОО
ТОГТВОРТОЙ
УРАГШЛАХ НЬ**

БАЙГАЛЬ ОРЧИН

6-11

Эх дэлхийгээ мөнхөд ногооноор нь хадгалья

- Агаарын бохирдлыг бууруулах хөрөнгө оруулалт
- Хог хаягдлаас үнэ цэн бүтээж буй хамтын ажиллагаа
- Усны дусал бүрийг хайрлая

НИЙГЭМ

12-29

Үлгэрлэн манлайлна

- Хариуцлагатай хэрэглээ
- Боловсролыг тэтгэх нь
- Үндэсний өв, соёлоор гоёно
- Цагаан хувьсгал
- Малчдын амьжиргаа, орон нутгийн
- Хөгжлийг дэмжих нь
- Дотоодын нийлүүлэгчдийг дэмжиж буй үйл ажиллагаа
- Олон нийтийн эрүүл мэнд

ЗАСАГЛАЛ

30-41

Тогтолцоогоороо тогтвортой урагшлах нь

- Бүх оролцогч талын эрх ашгийг хамгаалах нь
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ
- Эрсдэлийн удирдлага
- Бизнес ба хүний эрхийн хянан магадлагаа
- Бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдал
- Аюулгүй байдал

ХАМТ ОЛНЫ ХӨГЖИЛ

42-65

Хүн төвтэй засаглал

- АПУ Академи
- Менторшип
- Уян хатан ажлын цаг
- Хүүхдийн өрөө
- Хөхүүл ээжийн өрөө
- "Сонирхлын клуб"үүд
- Эрүүл мэндийг дэмжих нэгж
- "APU LIFE" хөтөлбөр
- Эрх тэгш, шударга байгууллагыг бий болгох нь
- Бидний туулсан зам
- Тогтвортой маргаашийн төлөөх тэгш, хүртээмжтэй өнөөдрийг бүтээх нь

ТУЗ-ИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ



ЦАГААН ХУВЬСГАЛ – ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ

эх орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах эрхэм зорилгын хүрээнд сүүний ханган нийлүүлэлт, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Монгол Сарлаг – Гэр үйлдвэрлэл”-ийн төслөө эхлүүлж, сүү сүүн бүтээгдэхүүн, бяслагийн үйлдвэр, малчдын тогтвортой амьжиргааг дээшлүүлэх нийгмийн шинж чанартай хөрөнгө оруулалтад онцгойлон анхаарч ажиллаж байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цагаан хувьсгал”-ыг түүчээлэн хэрэгжүүлэхэд сүүний бодлогын зөвлөл бий болгох, нэмүү өртгийн сүлжээний стратеги шинэчилж тогтоох, эрчимжсэн кластер ферм хөгжүүлэх, сүүний үнээний импортыг нэмэгдүүлэх, хүүхдийн сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутаг дахь чанарын лабораторийг чадавхжуулах зэрэг найман уриалгыг дэвшүүлээд байгаа юм.

Энэ хүрээнд бид “Цагаан хувьсгал”-ыг түүчээлэн хэрэгжүүлэхийг ирэх жилүүдийн тэргүүлэх зорилтын нэгээр тодорхойлж, ханцуй шамлан ажилдаа орж байгааг хувьцаа эзэмшигч та бүхэндээ онцлон тэмдэглэхэд таатай байна.

Монгол орондоо **“ЦАГААН ХУВЬСГАЛ”** хийцгээе.

Пүрэвийн

Батсайхан

Та бүхэнд АПУ ХК-ийн 2022 оны тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны талаар тайлагнан мэндчилж байна.

2022 онд Монгол Улс нийгэм-эдийн засгийн бүхий л талбарт Шинэ сэргэлтийг цогцлоох зорилго тавьсантай холбогдуулан бид нийгэмдээ хамтын үнэ цэн бүтээх, уламжлалаа хүндэлж шинийг бүтээх, үйл хэргээрээ үлгэрлэн манлайлахыг зорьж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг санаачилсныг хүнсний манлай үйлдвэрлэгч АПУ компанийн хамт олон бид талархан хүлээн авсан билээ. Анх 2014 онд сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт хөл тавьсан бидний хувьд дотоодын үйлдвэрлэлийг дэлхийн стандартад хүргэж,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ



төслийн хүрээнд шилний эргэлтийг 3 дахин нэмэгдүүлж, хариуцлагатай хэрэглээний соёлыг түгээх “Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй” аяныг амжилттай эхлүүллээ. Мөн орчны агаарын бохирдлыг бууруулахад чиглэж, хийн болон дизель түлшээр ажилладаг хосолсон уурын зуухыг ашиглалтад оруулсан. Ингэснээр АПУ компанийн “Тайгер” шар айргийн үйлдвэр нь байгальд ээлтэй инженерингийн шинэлэг шийдэл бүхий төслийг амжилттай хэрэгжүүлсэн Монгол Улсын төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй хүнсний үйлдвэрүүдийн нэг боллоо.

Бид хүн төвтэй засаглалын бодлогыг хэрэгжүүлэн, эрх тэгш, шударга, хүртээмжтэй байгууллагыг бий болгоход анхаарч, ажилчдынхаа ажил амьдралын тэнцвэрт байдал, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор “APU LIFE” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, ажлын уян хатан цагийн системийг шинээр нэвтрүүлэн, хүртээмжтэй ажлын байрыг бий болгоход чиглэсэн олон төлөвлөгөөт ажлыг бодлогын хүрээнд хэрэгжүүлж ажиллалаа.

Компанийн дараагийн 100 жилийн тэргүүн чиг, нөлөөллийг тодорхойлох Тогтвортой хөгжлийн стратегиа бид 2023 онд батлуулахаар ажиллаж байгааг дуулгахад таатай байна. Ингэснээр Тогтвортой хөгжлийн 17 зорилгоос байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хамгийн өндөр бөгөөд бодит хувь нэмрийг оруулах боломжийг зураглаж, үе шаттайгаар төвлөрөн ажиллах юм. Монгол Улсын хүнсний манлай үйлдвэрлэгчийн хувьд хүлээсэн хариуцлагадаа эзэн болж, эргээд эх дэлхий, нийгэмдээ үзүүлж буй нөлөөллөө хүн төвт бодлоготойгоо уяж ажиллаж байгаа талаар та бүхэн тайлангаас хүлээн авна уу.

Бид тогтвортой хөгжих үндсээ бататгах хүрээнд 2022 онд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллөө сайжруулах томоохон ажлуудыг эхлүүлж, урт хугацааны ач холбогдолтой ажлуудаа үргэлжлүүлэн гүйцэтгэсэн бөгөөд агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх ажлыг үйлдвэрийн хэмжээнд уурын зуух төслөөр дамжуулан нэвтрүүлж, шилний хаягдлаа эргүүлэн авч, дахин амьдруулахаас гадна хог хаягдлын хэмжээгээ тогтолцоогоор нь бууруулах, баруун бүсийн хамгийн том агуулах шинэ логистикийн төвөө ашиглалтад оруулсан зэрэг олон ажлын ард ийнхүү гарлаа.

Бид нийгэм, байгаль орчиндоо ээлтэй бизнес эрхэлж, тогтвортой хөгжлийн зарчмыг тууштай баримтлан, бодит хувь нэмрээ оруулж ажиллалаа. Үүнд байгальд ээлтэй төсөл хөтөлбөрүүдээ үргэлжлүүлж “Чи Чадна – Шилээ дахин амьдруулъя”

Цэвээнжавын

ЭРДЭНЭБИЛЭГ

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ УУРЫН ЗУУХНЫ ТӨСӨЛ

АПУ компанийн Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд нийгэм, байгаль орчиндоо ээлтэй “УУРЫН ЗУУХ”-ны төслийг АПУ ХК-ийн охин компани болох **М-БИ-СИ АЗИА ПАСИФИК**-ийн “Тайгер” шар айргийн үйлдвэрт амжилттай хэрэгжүүллээ.

Энэхүү төслийн хүрээнд хийгдсэн уурын зуух нь нийгэм, байгаль орчинд ээлтэй, агаарын бохирдол үүсгэхгүй, энергийн алдагдлыг бууруулах давуу талтай юм.

1 жилд
3000тн ТҮҮХИЙ НҮҮРС хэрэглээнээс халах боломжтой



“ ЭХ ДЭЛХИЙГЭЭ МӨНХӨД НОГООНООР НЬ ХАДГАЛЪЯ.

АГААРЫН БОХИРДОЛ ҮҮСГЭХГҮЙ

- 2098 кг (CO) хүлэмжийн хий
- 3714 кг (SO2) хүлэмжийн давхар исэл
- 4981 кг (TSP) тосонцор
- 1450 кг (NOx) азотын исгүүдэг
- 2098 кг (CO) хүлэмжийн хий
- 3714 кг (SO2) хүлэмжийн давхар исэл
- 4981 кг (TSP) тосонцор
- 1450 кг (NOx) азотын исгэл

ЖИЛД 3000тн түүхий нүүрсний хэрэглээг халсан.

ЭНЕРГИЙН АЛДАГДАЛ БУУРНА

БАЙГАЛЬД ХАЯГДАХ ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛСАН БИӨТН үнсний хаягдал.

Зуухны ашигт үйлийн **КОЭФФИЦИЕНТ 95%** болж нэмэгдэнэ.



**ХОГ ХАЯГДЛААС
ҮНЭ ЦЭН БҮТЭЭЖ
БУЙ ХАМТЫН
АЖИЛЛАГАА**

**ЧИ ЧАДНА – ШИЛЭЭ ДАХИН
АМЬДАРУУЛЬЯ ТӨСӨЛ**

АПУ ХК нь 2022 онд “Шилээ дахин амьдруулъя” төслийн үргэлжлэл болгон шилний хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах хэрэглээний хэв маягийг бүрдүүлэх зорилгоор “Чи чадна” төслийг амжилттай хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд хэрэглэгч, түгээгч, тээвэрлэлтийн байгууллага болох бүхий л оролцогч талуудыг хамруулан шилийг онцгой үнээр эргүүлэн авч харилцан эдийн засгийн өгөөжийг хүртэх зарчмаар нийт **960 гаруй** агентыг төсөлд нэгтгэж, шилний эргэлтийг **3 дахин** нэмэгдүүлж чадлаа.

Шилээ дахин амьдруулснаар түүхий эд, орц найрлагад орох байгалийн нөөц баялгийг хэмнэх, шилний импортын хамаарлыг багасгаж, хил гаалийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах, шил шинээр үйлдвэрлэхээс гарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зэрэг нийгэм эдийн засаг, байгаль орчинд ихээхэн өндөр ач холбогдолтой юм. Бид шингэн хүнсний салбарт тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаа байгальд орчинд ээлтэй, хариуцлагатай байх чиглэлд хамтын бодлого баримтлан ийнхүү ажиллаж байна.



АУДИТ



Байгаль орчны аудитын ажлыг АПУ ХК-д 2022 оны 11 сарын 15-12 сарын 15 өдөр хүртэл 30 хоногийн хугацаанд 7 бүрэлдэхүүн **134** шалгуур үзүүлэлтээр үнэлэн **95%**-ийн гүйцэтгэлтэй Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн заалтын дагуу аудитыг амжилттай хийлгэж чадлаа.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨДӨРЛӨГ



зүй зохистой ашиглах, хэмнэх, усыг дахин ашиглах үүднээс нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны хэрэглээг бууруулахад чиглэсэн бодлогыг танилцуулж, сурталчиллаа.

АПУ ХК нь компанийн ажилтнууддаа зориулан “Дэлхийн Усны өдөр” -ийг тохиолдуулан “Өнгө нэм” ТББ -тай хамтран “Эх Дэлхийгээ Хайрлаж, Усаа хэмнэе!” өдөрлөгийг зохион байгуулсан. Энэ үеэр АПУ компани нь “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-д хүрэхийн төлөө цэвэр усны эх үүсвэрийг хайрлан хамгаалах, нөөцийг



Нийслэлийн Байгаль Орчны газартай хамтран нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих ажилд АПУ ХК компани нь **1200 ширхэг** шилмүүс нарс мод тарихаар Мөнхантайшир ХХК хамтран ажиллахаар гэрээг байгуулж ажиллалаа.



ХОГ ХАЯГДЛААС ҮНЭ ЦЭН БҮТЭЭЖ БУЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

ШИНГЭН ХАЯГДАЛ

Шингэн хаягдлын хувьд үйлдвэрээс органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдэл, шар айраг шүүлтүүрийн материал кизельгур зэрэг гардаг ба дахин ашиглалтыг онцгой анхаарч ажиллаж байна.



Тухайлбал өмнө нь бид шар айргийн шүүлтийн процесст оролцдог Кизельгургыг хаягдал усны шугамд хаядаг байсан бол одоо шүүх хатаах төхөөрөмж суурилуулан хатуу хог хаягдал болгон ашиглаж байна. Кизельгур нь байгалийн нэгдэл бөгөөд агрохими хүнд металлын шинжилгээгээр стандартын шаардлага хангадаг учир газар тариалангийн салбар болон зам барилга салбарт ашиглах боломжтой гэдэг эрдэмтдийн судалгаан дээр үндэслэн судалгааны ажлыг “Ойм Ногоон урлан ХХК”-тай хамтран эхлүүлсэн. Үйлдвэрлэлээс гарч буй нийт хог хаягдлыг 9.8 хувийг эзэлдэг кизельгурийн эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг бид ийнхүү судалж байна. Үүний хамгийн том ач холбогдол нь хөрсний доройтол, цөлжилтийг бууруулахаас гадна төвлөрсөн хогийн цэгт очих хаягдлыг бууруулах үр нөлөөтэй юм.

ХАЯГДАЛ ШИЛ

Бид хаягдал шилээ дахин ашиглах зорилгоор Шинэ Шил ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу одоогийн байдлаар **400 орчим тонн** шилийг нийлүүлсээр байна. Хөөсөн шил үйлдвэрлэх туршилтыг анхлан явуулахад АПУ компанианаас гарч байгаа хаягдал шилний цахиур түүхий эдийн шаардлагыг бүрэн хангаж байсан тул ийнхүү эдийн засгийн эргэлтэнд оруулж эхэллээ. Хөөсөн шил нь импортыг орлох бүтээгдэхүүн бөгөөд галд тэсвэртэй, цантахгүй, бат бөх, амархан зүсэгддэг зэрэг олон давуу талт

УСНЫ ДУСАЛ БҮРИЙГ ХАЙРЛАЯ

УС АШИГЛАЛТ

Жил бүр усны хэрэглээг багасгах, хянах үүднээс “Ус ашиглалтын зардлын норм”-ыг шинэчлэн баталдаг. 2016 онд баталсан “Ус ашиглалтын зардлын норм”-ыг, БОНХАЖ сайдын 2015 оны А/301 тоот нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормтой харьцуулахад **1000 литр** бүтээгдэхүүн тутамд **2.1-3.5 дахин бага** ус зарцуулж байна.

СААРАЛ УС

Хаягдал усыг дахин ашиглах эх үүсвэр нь үйлдвэрийн тоног төхөөрөмжөөс хаягдаж байгаа ус тооцогдох ба үүнийг дахин ашиглаж Улаанбаатар хотын ногоон байгууламжийн усалгаа, угаалга, ариутгал хийхэд ашиглаж байна. Мөн үүнээс гадна үйлдвэр цехийн анхан шатны угаалга цэвэрлэгээ, үйлдвэрийн ариун цэврийн өрөөний суултуур зэрэгт ашиглаж байна. Усны шүүлтийн систем болон савлах үйлдвэрийн зайлсан усыг эргүүлэн ашиглах замаар нийт **13,123 м3** саарал усыг ашигласан байна.

НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙ

Шар айрагний исгэлтээс ялгарч байгаа нүүрсхүчлийн хийг агаарт буюу байгаль орчинд хаялгүй боловсруулж нийт 2,102,341кг нүүрсхүчлийн хийг үйлдвэрлэлд дахин ашигласан.

WORLD ENVIRONMENTAL DAYS

ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР

2022 онд АПУ ХК **13,128 м3** УС ДАХИН АШИГЛАСАН.

ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЖ УСАА ХЭМНЭЭ!

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

ЦАХИЛГААН, ДУЛААН, УУР, УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Байгалийн нөөцийн хэмнэлтийн зорилгын хүрээнд дулаан, цахилгаан эрчим хүч, усны хэрэглээгээ зорилтот түвшнээс давуулан бууруулж өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулааны хэрэглээг **17.3%**, цахилгааны хэрэглээг **8.4%**, усны хэрэглээг **22.6%** -иар тус тус бууруулсан байна. Эрчим хүчний зарцуулалтыг бууруулах, дулааны алдагдлыг багасгах чиглэлээр тоног төхөөрөмж, техник, технологид томоохон хөрөнгө оруулалтыг хийсний дүнд **204,216 мян.кВт/цаг** цахилгаан эрчим хүч, **3.0 мян. Гкал** уурыг хэмнэж, нийт **1700 гаруй** гэрлийг эрчим хүчний хэмнэлттэй LED технологид шилжүүлснээр гэрэлтүүлэгт зарцуулах эрчим хүчийг **54%**-иар бууруулсан байна.

УЛГЭРЛЭН МАНЛАЙЛНА

ГАЙХАМШИГТ ЖОЛООЧ УУСАН БОЛ ЖОЛОО БАРЬДАГГҮЙ

“АПУ” ХК нь нийгмийн манлайллын “Соёлоор гоёно” төслийн дэд хэсэг болгон хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд компанийн тогтвортой хөгжлийн бодлогын нэг хэсэг болох “Хариуцлагатай хэрэглээ”-г бий болгох зорилгоор замын хөдөлгөөний аюулгүй байдал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг “Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй” хөтөлбөрийг хэрэгжүүлж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын хор уршгийг нийгэмд таниулах, зөрчлөөс сэргийлэх арга зам, жолоодлогын үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр “АПУ” ХК, Тээврийн Цагдаагийн алба, “UBCab” байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг олон улсын зан төлөвийн судалгаанд суурилан явагдаж байгаагаараа онцлог юм. Олон улсын судалгаагаар нийгмийн зан төлөвийн хувьд хэрэглэгч өөрийн жолоодлогын туршлага, арга барилыг сайн, хангалттай гэж үнэлсний улмаас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох хандлага давамгайлдаг аж.



Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл барихгүй байх, жолооч дуудах арга хэрэгслийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байдаг тул богино хугацаанд зохисгүй шийдвэр гаргалт хийж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож улмаар зөрчил үүсгэж, ноцтой хохирол учруулах эрсдэлийг үүсгэдэг байна. Иймд АПУ компани согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг нөлөөллийн хөтөлбөрийг эхлүүлж, нийгмийн эерэг нөлөөллийн төлөө олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлсээр байна.

АПУ ХК-ийн Соёл өөрчлөлтийн дотоод харилцааны ажилтан Д.Хэрлэн

**ХАЙРТАЙ БҮХНИЙХЭЭ ТӨЛӨӨ
#ГАЙХАМШИГТ_ЖОЛООЧ
БАЙХАА БИ АМЛАЖ БАЙНА.
ТА Ч ГЭСЭН АМЛАЛТАА
ӨГӨӨРЭЙ.**





БОЛОВСРОЛЫГ ТЭТГЭХ НЬ

Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусыг дэмжих “МАРГААШИЙН МАНЛАЙЛАГЧИД” төсөл

Нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах манлайлагчдыг нээн илрүүлэх, тэдний сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 100 оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг АПУ ХК нь 2021-2022 оны дунд хүртэл хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд “Хүний хөгжлийн тогтвортой бодлого” -д онцгойлон анхаарч хөтөлбөрт оролцогч оюутан залуусыг нийгэмдээ эерэг хандлага түгээж бусдыг хүндлэх, ойлгох соёлыг дэлгэрүүлэх зорилготой сургалтуудад шат дараатай хамрууллаа.

Тухайлбал НҮБ-ын Залуучуудын Зөвлөх Хорооны “Global Goals for Youth” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “ЗҮРХЭЛ” төсөлтэй хамтарч Дохионы хэлний хурууны үсэг, энгийн өдөр тутмын хэллэгүүдийг заах сургалтыг амжилтай зохион байгуулснаар бид сайн сайхан, хүн бүрт хүртээмжтэй нийгмийг цогцлооход хувь нэмрээ оруулж, нийгэмд чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн төслийн хүрээнд Хип Хоп бүжгийн урлагт дурлагч энэ төрлөөр сонирхон хичээллэгч хүүхэд залуусыг дэмжиж, олон нийтэд Хип Хоп бүжгийг сурталчлан таниулах зорилготойгоор “Монголын Гудамжны Хип Хоп бүжгийн холбоо”-той хамтран “Level_Up.vol.4 Hip hop battle”-ийг зохион байгууллаа.

“SPIRIT OF GOBI 2022” ART AND MUSIC FESTIVAL

АПУ ХК-ийн нийгмийн эерэг өөрчлөлтийн “Соёлоор Гоёно” төсөл #SocialiseResponsibly уриатайгаар дэлхийд Монголыг сурталчлах зорилготой “Spirit of Gobi” Art and Music Festival-ыг 2022 онд амжилттай зохион байгуулсан. Энэ хүрээнд залуус, нийгэм, олон нийт, хэрэглэгчдийн дунд хэрэглээний соёлыг төлөвшүүлж, байгальд ээлтэй, хариуцлагатай, зөв зохистой хэрэглээг таниулах үүднээс “Spirit of Gobi” наадамд оролцсон бүх зочдодоо бид хаягдал шилээр бүтээл хийж, цагийг дурсамж дүүрэн өнгөрөөх боломжийг олгохоос гадна НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилтын нэг болох “Хариуцлагатай хэрэглээ”-ний ач холбогдлыг сурталчилсан юм.




“ ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛООР ГОЁНО ”



АПУ ХК нь нийгмийн эерэг өөрчлөлт бий болгох зорилготойгоор **“Соёлоор Гоёно”** төслийг **2021** оноос эхлүүлэн **2022** онд үргэлжлүүлж, үндсэн гурван чиглэлийн хүрээнд нөлөөллийн кампанит ажлыг үе шаттайгаар зохион байгуулсаар байна.

Үүний үр дүнд байгаль эх дэлхийдээ ээлтэй амьдрах соёл, хариуцлагатай хэрэглээний дадлыг түгээн дэлгэрүүлж, язгуур өв соёлоо сурталчлан **“Дэлхийд Монгол Соёлоор Гоёно”** хэмээх уриан дор дэлхийн **15 улс**, эх орныхоо **30 гаруй** цэгээс хамтдаа биелгээ хийж үндэсний соёлоороо гоёлоо.



ҮНДЭСНИЙ ИХ ӨВ “СОЁЛООР ГОЁНО”

АПУ компани нь уламжлал, өв соёлоо эрхэмлэн дээдэлж, шагайн харваа, сур харваа, хурдан морь, үндэсний бөх тэргүүтэй үндэсний спортын төрлүүдийн тамирчидтай хамтран ажиллаж байна.



“МӨНГӨН МОД” НААДАМ

“Соёлоор Гоёно” төслийн хүрээнд бид өнгөрсөн хугацаанд нийт **55 гаруй** төрлийн контентыг олон нийтэд түгээж, өөрсдийн бүтээхийг хүсдэг соёлыг түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан хамтын дуу хоолой, хүсэл тэмүүлээ төслөөр дамжуулан илэрхийлсээр байна. Энэхүү нийгэмд чиглэсэн “Соёлоор Гоёно” төсөл нь **13 дахь** удаагийн соёл, урлаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын “Мөнгөн Мод” наадамд “Шилдэг зар сурталчилгаа” төрөлд шалгарсан анхны бүтээл боллоо.



ЦАГААН ХУВЬСГАЛ



АПУ компани Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг сүүний салбарт “Цагаан хувьсгал” хийх уриалгаар дэмжин үргэлжлүүлэх саналыг дэвшүүллээ.

Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь шингэн сүүний нийлүүлэлт, тээвэр логистикоос шууд хамааралтай бөгөөд цаашид “Цагаан хувьсгал”-ын хүрээнд дэвшүүлсэн дээрх найман уриалгыг хэрэгжүүлэхэд АПУ компани онцгойлон дэмжихээ ийнхүү илэрхийллээ.



Энэхүү уриалгын хүрээнд цаашид сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамжийн НЭМҮҮ өртгийн сүлжээг цогцоор нь шийдэх гарц гаргалаа эрэлхийлж, сүүний салбарын “Цагаан хувьсгал” уриалгыг хэрэгжүүлэхийг **АПУ ХК-ийн Төсөл эрхэлсэн захирал Г.Энхбилэг** онцолсон бөгөөд сүүний бодлогын зөвлөл бий болгох, нэмүү өртгийн сүлжээний стратеги шинэчилж тогтоох, эрчимжсэн кластер ферм хөгжүүлэх, анхан шатны боловсруулах үйлдвэрт татварын хөнгөлөлт үзүүлэх, сүүний татаасны хугацааг нэмэгдүүлэх, сүүний үнээний импортыг нэмэгдүүлэх, хүүхдийн сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутаг дахь чанарын лабораторийг чадавхжуулах зэрэг найман уриалгыг дэвшүүллээд байгаа юм.



АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэрийн Гүйцэтгэх захирал Г.Баярмагнай: “Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гол хэрэгцээ нь шингэн сүүний нийлүүлэлт бөгөөд малчид фермерүүдийг дэмжин ажиллаж, ойрын таван жилийн хугацаанд сүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. “Цагаан хувьсгал” уриалгын хүрээнд дэвшүүлсэн арга замын хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниуд дотоодын хэрэгцээг хангахад чиглэж, сүүний салбарын жишиг кластер ферм, дэд бүтэц, ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, цогцоор нь шийдэхэд анхаарч ажиллах шаардлага үүсэж байна. Үүнд АПУ ХК, АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр хөрөнгө оруулалт хийж, Монгол хүний сүүний хэрэглээг 3-5 дахин өсгөх зорилготой ажиллаж байна.”

“МАЛЧДЫН АМЬЖИРГАА, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ

“МОНГОЛ САРЛАГ” - ГЭР ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨСӨЛ

Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь шингэн сүүний нийлүүлэлт, тээвэр ложистикоос шууд хамааралтай бөгөөд малчин өрхийн амьжиргааг дэмжих анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийг бий болгоход чиглэн АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь “МОНГОЛ САРЛАГ” - Гэр үйлдвэрлэлийн төслөө Архангай аймгийн Чулуут суманд 2022 онд эхлүүлээ.

Төслийн хүрээнд тус сумын эхний 20 өрхтэй хамтын ажиллагааны гэрээг байгуулан малчдаас дээж бүтээгдэхүүнийг хуримтлуулж, туршилт судалгааг тасралтгүй явуулснаар түүхий эдийн татан авалт оновчтой болж, улирлын нөлөөлөл багасаж, малчин өрхийн орлого тогтмолжиж, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлж буйг малчид онцолж байна. “МОНГОЛ САРЛАГ” - Гэр үйлдвэрлэлийн төсөл нь цагаан идээний уламжлалт үйлдвэрлэлд хүнсний эрүүл ахуйн стандарт бий болгон мөрдөхийн зэрэгцээ, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, түгээлтийн нэгдсэн системийг бий болгож байна.



“ ДОТООДЫН НИЙЛҮҮЛЭГЧДИЙГ ДЭМЖИЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АПУ компанийн нийт бэлтгэн нийлүүлэгчдийн **78%**-ийг дотоодын бизнес эрхлэгчид бүрдүүлдэг бөгөөд бид хамтран ажиллагч, түншүүд, бэлтгэн нийлүүлэгчдийнхээ алс ирээдүйн бизнесийн үйл ажиллагааг өргөжин хөгжүүлэхэд найдвартай түнш байж, тогтвортой бодлогыг баримтлан хамтын үнэ цэнийг бүтээн ажиллаж байна.

ШИЛМЭЛ СОРТЫН УЛААНБУУДАЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ

АПУ ХК-ийн гол түүхий эд болох улаанбуудайн нийлүүлэлтийг дотоодын **60 гаруй** аж ахуй нэгж бүрдүүлдэг бөгөөд нийт бэлтгэн нийлүүлэлтийн **40%**-ийг Сэлэнгэ **Тариа ХХК** нь дангаараа нийлүүлдэг. Бид нийт тариалан эрхлэгчдийн бизнесийн тогтмол үйл ажиллагааг бүрдүүлэх хүрээнд уян хатан бодлогын системийг нэвтрүүлэн, тариалалтын урьдчилсан урамшуулал олгож, тогтвортой үйл ажиллагааг нь тогтмол дэмжин ажиллаж байна.

САВ БАГЛАА БООДОЛ, ХУВАНЦАР БЭЛДЦИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ

АПУ компанийн ус ундаа, шар айргийн үйлдвэрлэлийн хуванцар бэлдцийг **ЦЭЦ ЗАМ ПЛАСТ ХХК**, бүх төрлийн сав баглаа боодлын зориулалттай цаасан хайрцгийг **ГОФРО ХХК** 11 жил тасралтгүй нийлүүлэн хамтран ажиллаж байгаа бол бүх төрлийн багцлагч, ороогч хальс үйлдвэрлэлийн нийлүүлэлтийг **МУЛЬТИПАК ХХК** нь 13 жилийн турш дангаараа ханган ажиллаж байна.

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, ГУТЛЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ

АПУ компани нь үйлдвэрийн ажилчдын хөдөлмөр аюулгүй байдалд онцгойлон анхаарч ажилладаг. Энэ хүрээнд дотоодын үйлдвэрлэгч **БЕСТШҮЕС ХХК** - тай 2008 оноос хойш хамтран ажиллаж, жилд дунджаар компанийн хэрэгцээний **1000-2000** хөдөлмөр хамгааллын хос гутлыг тогтмол худалдан авч байна. Мөн хөдөлмөр хамгааллын хувцас үйлдвэрлэдэг **ӨҮЛЭН МЭНЧ ХХК** - тай 2010 оноос хойш хамтран ажиллаж, нийт ажилчдынхаа хавар намрын хөдөлмөр хамгааллын ажлын хувцасны хэрэгцээг **100%** хангаж байна.



ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД

ОРГИЛУУН ЛИГ

Оргилуун брэндтэй ОРГИЛСОН их хүслээр нэгдсэн, сагсан бөмбөгт хайртай дуртай залуусыг АПУ ХК-ийн Оргилуун брэнд үргэлж дэмждэг. 2022 оны Монголын хамгийн олон сагсан бөмбөг сонирхогч залуус оролцсон Сонирхогчдын Сагсан Бөмбөгийн **ОРГИЛУУН ЛИГ** амжилттай зохион байгуулагдаж аваргуудаа тодруулсан бөгөөд нийт **56** багийн **1000 гаруй** тамирчид, **100 гаруй** дасгалжуулагчид оролцож, 5 сарын турш ширүүн өрсөлдөн **АВАРГА** багаар **“ЗАВХАН ГАРДИ”** баг шалгарч Дэд байрт **“МУИС ШОНХОРУУД Hi-Pay Diamond”** баг Гутгаар байрт **“ЗАВХАН БРОДЕРС”** баг тус тус шалгарсан юм. Тоглолтын шийдвэрлэх үе Аваргын төлөөх тоглолтод **“ЗАВХАН ГАРДИ”** 77-76 **“МУИС Шонхорууд”** Цувралын гурав дахь тоглолтод **“ЗАВХАН ГАРДИ”** баг хожсоноор лигийн аваргаар тэд тодорсон юм.



ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ

АПУ ХК нь залуучуудын эрүүл мэндийн зохистой дадал, хэвшлийг бий болгох зорилгоор сагсан бөмбөгийн спортын хөгжилд хувь нэмэр оруулан **“Монголын Сагсан Бөмбөгийн Холбоо”** / МСБХ/-ны Үндэсний дээд лигийг урт хугацаандаа дэмжин хамтран ажиллаж байна. Тухайлбал АПУ ХК-ийн **Сэнгүр брэнд** нь 2013 оноос Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбооноос зохион байгуулдаг Монголын хамгийн том, чансаа өндөртэй Супер Лиг болон Үндэсний 21 аймгийн лигийн ерөнхий ивээн тэтгэгчээр тасралтгүй 9 жил ажиллаж, спортод хайртай залуусын сонирхол, хүсэл тэмүүллийг ийнхүү дэмжсээр байна. Энэхүү спортын хамтын ажиллагааны үр дүнд спортын лигийн маркетинг, менежментийн үйл ажиллагааг цоо шинэ түвшинд хүрсэн бөгөөд АПУ ХК-ийн зүгээс **ҮСБХ**-той хамтран **NBA**-н медиа сувгийн гол контентууд болох **TOP 10, Highlights, Shaqtin' A fool** зэргийг анхлан нэвтрүүлж, **Лигийн нээлт, All Stars, Play Off, Final** тоглолтуудыг мэргэжлийн өндөр түвшинд олон нийтэд хүргэж ажиллаж байна.



ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД


СҮҮНИЙ АШИГ ШИМ

Хүүхэд бүр эрүүл саруул өсөн торниход сүү сүүн бүтээгдэхүүний оруулах үр нөлөө өндөр гэдгийг мэргэжилтнүүд онцолдог. Иймд сүүний хэрэглээ, ач холбогдлыг эцэг эх, хүүхэд багачуудад таниулах зорилгоор “Дэлхийн Сүүний Өдөр”, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан АПУ Дэйри ХХК-ийн зүгээс “GOOD VIBE” брэндийн асрыг Улаанбаатар хотын 3 цэгт байршуулан сүүний ашиг шимийг олон нийтэд сурталчиллаа. Бид Монголчуудынхаа сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангах, импортыг орлохуйц, хүнс урлахуйн уламжлалт ур, ухааныг шинэчлэл, дэвшилтэй хослуулан хөгжүүлсэн “Сайн”, “Дээж”, “Good Vibe”, “Цэвэр сүү” буюу үндсэн 4 брэндийн 40 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэн ажиллаж байна.



МАНДАЛ СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙГ СББ ДУЛААНЫ СТАНЦТАЙ ХОЛБОЛОО

АПУ ХК-ийн охин компани Спирт Бал Бурам (СББ) ХХК Сэлэнгэ аймгийн Мандал суманд байрлалтай бөгөөд 1973 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж, сумын хөгжил дэвшлийн салшгүй хэсэг болсоор ирсэн. Мандал сум нь нийт 30-аад мянган хүн амтай томоохон сум бөгөөд өнөөгийн байдлаар нийт 440 айл өрх, 17 аж ахуйн нэгж, төрийн өмчит цэцэрлэг, сургуулиуд, баг хорооны нутгийн удирдлагын байр зэрэг нь СББ ХХК-ийн Дулааны станцаас дулаанаар хангагдсан. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн дэргэдэх нам даралтын зуухнуудыг багасгаж төвлөрсөн дулаан хангамжид шилжүүлэх ажлуудыг СББ ХХК үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлж ирсэн. 2022 онд АПУ компанийн шийдвэрээр СББ ХХК-ийн Дулааны станц үйл ажиллагааныхаа орон нутаг дахь хүртээмжээ нэмэгдүүлж, 250 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 256м дулаан, хэрэгцээний халуун усны хос шугамууд болон Дулаан дамжуулах төвийг Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн хуучин зуухны дэргэд байгуулж ашиглалтад орууллаа. Сумын эрүүл мэндийн үйлчилгээний гол ачааг дааж яваа тус нэгдсэн эмнэлэг нь гар ажиллагаа шаарддаг нам даралтын зуухтай байсан нь эмнэлгийг зохистой стандартын хэмжээнд жигд халаах хүчин чадал дутмаг, хэрэгцээний халуун усаар хангах боломжгүй байв. Өвлийн хүйтэнд Эмнэлгийн төрөх тасгийн коридорт 11 хэмийн дулаантай байсан бөгөөд дулаанаас гадна халуун усны найдвартай



эх үүсвэргүй байсан нь эмэгтэйчүүдийн амаржих, эмнэлгийн ажилтнуудын эх барих, нярайн асаргаанд удаан хугацаанд хүндрэл учруулж байсныг СББ ХХК-ийн Дулааны станцад холбосноор Сумын олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, тав тухтай байдлыг бодитоор дээшлүүлсэн ажил болсон.

СББ Дулааны станц нь Нэгдсэн эмнэлэгтэй шугам сүлжээгээр холбогдсоноор 2023 онд 30-40 хувийн хүчин чадлаар ажиллах боломж бүрдсэн ба Мандал сумын 20-30 хувийг дулаанаар хангана. Цаашдаа тус станц 90 хувийн ачааллыг даан ажиллахад Мандал сумын хагасыг дулаанаар хангах бүрэн боломжтой юм. Энэ нь хүйтний улиралд томоохон асуудал болж буй Мандал сумын агаарын бохирдлын асуудлыг уурын зуухны яндангуудыг цөөлснөөр маш богино хугацаанд багасгах, оршин суугчдын амьдралын чанарыг дээшлүүлэх, ачааллыг хөнгөвчлөх боломж учир СББ ХХК нь дулааны станцынхаа шугам хоолойг үргэлжлүүлэн өргөтгөх ажлаа жил бүр тогтмол хийхээр төлөвлөж байна. Эхний ээлжид нэгдсэн эмнэлгийг холбон ажилласан нь орон нутагт хамтын үнэ цэн бүтээх, компанийн хариуцлагатай үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх зайлшгүй ажлуудын нэг байлаа.

Орон нутгийн удирдлагатай хамтарч Мандал сумын оршин суугчид болон ААН-үүдэд амьдралын таатай орчин бүрдүүлэх, шаардлага хангасан дулааны эрчим хүчээр хангах, тэр хэмжээгээрээ компанийн алдагдлыг бууруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэхэд дулааны шугам сүлжээг өргөтгөх ажил нь чухал ач холбогдолтой юм.

ТОГТОЛЦООГООРОО ТОГТВОРТОЙ УРАГШЛАХ НЬ

БҮХ ОРОЛЦОГЧ ТАЛЫН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ НЬ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАВ.

Компанийн засаглалын кодекс (цаашид “кодекс” гэх)-ийн зорилго нь компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Компанийн засаглал нь компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах тогтолцоо бөгөөд байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо юм. Мөн энэ ойлголтод хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа багтана.

Компанийн засаглалын сайн туршлагыг хэрэгжүүлснээр тухайн компанийн үнэлгээ өсөх, өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр татах, урт хугацаанд тогтвортой хөгжихөд ач холбогдолтой.

СЗХ-ноос 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан ба шинэчлэгдсэн кодекс дараах 9 зарчмыг тодорхойлж, хувьцаат компаниуд, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сангуудад заавал мөрдүүлэх үүрэг хүлээлгэсэн юм.

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх

КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОЙМ

2022.03.23 СЗХ-ноос Кодексийг шинэчлэн батлав.

2022.05.06 Кодексийн шаардлагын дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчилж, хороодын даргаар хараат бус гишүүдийг томилов.

Аудитын хороо	Нэр дэвшүүлэх хороо	Цалин урамшууллын хороо
• Ж.Үнэнбат (Хорооны дарга)	• О.Одбаяр (Хорооны дарга)	• Ё.Гэрэлчулуун (Хорооны дарга)
• Сэн И-Иин	• П.Батсайхан	• Ж.Үнэнбат
• О.Одбаяр	• Ё.Гэрэлчулуун	• Кеннет Чу

2022.05.18 ТУЗ-өөс Кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталснаар засаглалын 18 бодлого, дүрэм, журмыг шинээр (6) болон шинэчлэн (12) боловсруулах ажил эхлэв.

2022.06.09 МХБ-ээс Кодексийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг батлав.

2022.06.16 Компаниас шинэчилсэн Кодексийн хэрэгжилтийг үнэлэх анхны өөрийн үнэлгээг хийв.

2022.12.07 Кодексийн шаардлагын дагуу ТУЗ-ийн Аудитын хороонд шууд тайлагнах чиг үүрэг бүхий Дотоод аудитын нэгжийн удирдлагыг ТУЗ-с томилов.

2022.12.07 Кодексийн шаардлагын дагуу ТУЗ-д тайлагнах чиг үүрэг бүхий Комплайнс нэгжийн удирдлагыг ТУЗ-с томилов.

2022.12.26 Кодексийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн батлах 12 бодлого, дүрэм, журам болон шинээр батлах 2 баримт бичиг (“Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого”, “Бизнесийн ёс зүйн дүрэм”)-ийг боловсруулж дуусган, батлуулахаар ТУЗ-д танилцуулав.

2023.01.24 ТУЗ-ийн хурлаас Компанийн засаглалын 15 дотоод дүрэм, журмуудын шинэчлэн болон шинээр баталсан.

ЗАСАГЛАЛЫН ДОТООД ЖУРМУУДЫН ШИНЭЧЛЭЛ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам;
2. Ногдол ашгийн бодлого;
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
4. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журам;
5. ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журам;
6. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журам;
7. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам;
8. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам;
9. Цалин урамшууллын бодлого;
10. Залгамж халааны бодлого;
11. Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;
12. Дотоод аудитын бодлого;
13. Эрсдэлийн удирдлагын бодлого;
14. Дотоод хяналтын бодлого;
15. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого.

2023.02.13 ТУЗ-ийн хурлаас Бизнесийн ёс дүрмийн багц бодлогын баримт бичиг болох 15 бодлого дүрмийг баталсан.

Кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн эхний үе шат амжилттай хэрэгжсэнийг ТУЗ-ийн хуралд танилцуулж, хөтөлбөрийн дагуу хоёрдугаар үе шатны ажил болох дараах бодлогын баримт бичгүүдийг боловсруулж эхэлсэн.

БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ:

1. Хүний эрхийн бодлого
2. Өрсөлдөөний бодлого
3. Авлигын эсрэг бодлого
4. Бэлэг хандивын бодлого
5. Мөнгө угаах, хориг арга хэмжээний бодлого
6. Ашиг сонирхлын зөрчлийн бодлого
7. Компанийн хөрөнгө ашиглах бодлого
8. Залилангийн эсрэг бодлого
9. Нууц мэдээллийн бодлого
10. Оюуны өмчийн бодлого
11. Олон нийтийн сүлжээ ашиглах бодлого
12. Согтууруулах ундааны хариуцлагатай хэрэглээний бодлого
13. Нийлүүлэгчийн дүрэм
14. Шүгэл үлээх бодлого
15. Сахилгын арга хэмжээний бодлого

2023.03.28 Кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн эхний үе шат амжилттай хэрэгжсэнийг ТУЗ-ийн хуралд танилцуулж, хөтөлбөрийн дагуу хоёрдугаар үе шатны ажил болох дараах бодлогын баримт бичгүүдийг боловсруулж эхэлсэн.

БОЛОВСРУУЛЖ БҮЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД:

1. Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги
2. Комплайнсын хяналтын заавар/гарын авлага
3. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах бодлого, журам

2023.03.28 Компанийн засаглалын өөрийн үнэлгээ 94% байна.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Монголын хөрөнгийн бирж (цаашид “МХБ” гэх)-ийн Гүйцэтгэх захирлын 2022.06.09-ний өдрийн А/58 тушаалаар баталсан аргачлалын дагуу Компаниас Кодексийн хэрэгжилтийн үнэлгээг анх 2022.06.16-ны өдөр хийж, МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.

Улмаар эхний үнэлгээнээс хойш 2022 оны үйл ажиллагааны тайлан бэлтгэх өдөр хүртэл хэрэгжүүлсэн ажлыг дүгнэн, 2023.04.01-ний өдрийн байдлаар өөрийн үнэлгээг давтан хийж, үнэлгээний нэгдсэн үр дүнг 2022.06 сарын үнэлгээтэй харьцуулсан байдлаар дор танилцуулав. Үнэлгээний асуулгын дагуух дэлгэрэнгүй тайлан МХБ-ийн цахим хуудсанд байршина.

АПУ ХК ЗАСАГЛАЛЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭНД 94%-ИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР “ЗАСАГЛАЛ ХЭВИЙН, ЭРСДЭЛГҮЙ” ТҮВШИНД ҮНЭЛЭГДЛЭЭ.

АПУ ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

	Гарчиг	2022.06.16-ны өдрийн байдлаар			2023.04.01-ний өдрийн байдлаар			2022/2023 өсөлт
		Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	75%	12	12	100%	25%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8	80%	10	9	90%	10%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	6	100%	0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%	6	6	100%	17%
5	Эрсдэлийн удирдлага	8	6	75%	8	7	88%	13%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	3	50%	6	6	100%	50%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75%	8	8	100%	25%
8	Компанийн соёл	6	3	50%	6	6	100%	50%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%	10	8	80%	0%
	Нэгдсэн дүн	72	54	75%	72	68	94%	19%
		2. Дунд засаглалтай			1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй			1 түвшин ахив.

Тайлбар:

1. Нийт онооны 90% болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
2. 70-89% байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
3. 50-69% байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
4. 49% болон түүнээс доош бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл, түүнд авч буй хариу арга хэмжээ

Дэлхийн хэмжээнд

- **САНКЦ, БОЙКОТ, ХЯЗГААРЛАЛТУУДАД МОНГОЛ УЛС ӨРТӨХ**
- **ЭДИЙН ЗАСГИЙН УНАЛТ**
Өр, хүүгийн дарамт
Инфляцын дарамт
Валютын ханшийн хэлбэлзэл
Хөрөнгө оруулалт хумигдах
- **БАЙГАЛИЙН ГАМШИГ, ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТҮҮД**
Бараа таваарын үнийн өсөлт, шок
Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ТЭМ тасалдах
- **ХҮНИЙ НӨӨЦ, НИЙГМИЙН ХЯМРАЛ**
Халдварт өвчний тархалт
Ажиллах хүчний дутагдал
Нийгмийн сөрөг хандлага
Хэрэглэгчийн худалдан авах чадварын бууралт
- **КИБЕР ЭРСДЭЛ**
Кибер халдлагууд



- Эдийн засаг/Санхүү
- Байгаль орчин
- Нийгэм
- Дотоод
- Геополитик

ТОП ЭРСДЭЛҮҮД

ӨРТӨГ ЗАРДЛЫН ӨСӨЛТ

ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?

Орос Украины үргэлжилсэн зөрчилдөөнт байдлаас үүдэлтэй гол бараа таваарын нийлүүлэлтийн саатал, тээвэр логистикийн асуудал нь үнийн хөөргөдлийг бий болгож, улмаар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлэн хүлээгдэж буй ашиг орлогын өсөлтийг сааруулахаар байна. Мөн инфляцтай холбоотойгоор амьжиргааны зардал өсөж хэрэглэгчийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөн бүтээгдэхүүний үнийн бодлогыг харилцан зохист түвшинд барихад хүндрэл үүсгэх эрсдэлтэй.

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?

Энэ чиглэлд эрсдэлийг бууруулах/сулруулах стратегийг баримталж байгаа ба брэнд портфолио менежментийг оновчлох, санхүүгийн сахилга баттай, ухаалаг зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэх, компанийн хэмжээнд зардлын хэмнэлтийн санал санаачилгыг тогтмол хүлээн авч, бодитоор хэрэгжүүлэн ажиллаж байна.

НИЙЛҮҮЛЭЛТ ТЭМ ТАСАЛДАЛ

Геополитикийн асуудлаас улбаатай тээвэр логистикийн саатал, хил гаалийн хязгаарлалтууд үүсэж, үүний улмаас компанийн ТЭМ цаг хугацаанд ирэхгүй байх, бэлтгэн нийлүүлэгчтэй хийх гэрээ, төлбөр тооцоо шилжүүлэг хойшлох, агуулахын зай талбай ашиглалтын ачааллыг нэмэх зэрэг борлуулалт, үйлдвэр төлөвлөлтөд томоохон сорилтыг бий болгож байна.

Энэ төрлийн эрсдэлээс зайлсхийхийн тулд гэнэтийн ямар ч өөрчлөлтөд бэлэн, уян хатан менежменттэй байх түүнтэй уялдсан бүтэцтэй болох, Бизнесийн тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөөг баримтлан үйлдвэр төлөвлөлтийн цогц үйл ажиллагааг оновчлох ажлуудыг хийж байна.

ХҮНИЙ НӨӨЦ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДУТАГДАЛ

Дэлхий дахинд тулгарсан цар тахал түүнээс үүдсэн сөрөг үр дагаврууд нь нийт ажиллах хүчний бие физиологийн болоод сэтгэл зүйн хямралуудыг дагуулж бүтээмж сулрах, ажлаас халсрах хам шинж илрэх, ажлаас гарах орох урсгал нэмэгдэх, мөн шинэ үеийн залуусын зан төлөвт уялдуулан удирдах болон хамтран ажиллах арга барилаа өөрчлөх шаардлага үүсэх зэрэг хүнтэй холбоотой эрсдэлүүдийг дагуулж үүнд ихээхэн анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байна.

Ажилтнуудын сэтгэл зүйн эрүүл мэндэд чиглэсэн олон төсөл хөтөлбөр, сургалт уулзалтуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: "APU LIFE", "GOOD PLACE TO WORK". Мөн хүн төвтэй бодлогын хүрээнд сургалт хөгжлөөр тасралтгүй хангах зорилгоор сургалтын академиудыг үүсгэн байгуулсан.

НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, СӨРӨГ ХАНДЛАГА

Ядуурал, гэмт хэрэг, хүчирхийлэл зэрэг нийгмийн томоохон асуудлуудыг хөндөхдөө компанийн үйл ажиллагаатай холбох байдлаар олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр хүндэд шууд халдах, сөрөг мессежийг түгээх, нэр хүндэд томоохон нөлөөлөл үзүүлэх санаатай үйлдлүүд нэмэгдэх магадлал өндөр байна.

Хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор архи, согтууруулах ундааны спиртийн градусыг шат дараатай бууруулах арга хэмжээг авч ажиллахын зэрэгцээ соёлтой хэрэглээг таниулан сурталчлах олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэн ажиллаж байна.

КИБЕР ЭРСДЭЛ

Техник технологийн хурдацтай өөрчлөлт, шинэчлэлт, цахим шилжилтүүд нь өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчилж, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх олон давуу тал, боломжийг бий болгож байгаа хэдий ч кибер халдлагууд болох phishing, scareware, Scam зэрэг сэжигтэй имейл ирэх залиланд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Компанийн хэмжээнд ISO27001:2013 Мэдээллийн системийн чанарын тогтолцоог нэвтрүүлэхээр бэлтгэж байгаа ба нийт ажилтнуудыг сэрэмжтэй байх тал дээр сургалт, мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.



БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН ХЯНАН МАГАДЛАГАА

АПУ компанид хүний эрхийн сөрөг нөлөөллийн эрсдэл бий эсэх, хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тайлагнах зорилгоор “Хүний эрхийн хянан магадлагаа”-г MDS Khanlex хуулийн фирм, IWFCI Mongolia ТББ зэрэг байгууллагуудтай хамтран хийлээ.

Уг судалгааг хийхдээ компанийн дотоод батлагдсан дүрэм журам нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц: “Хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” зэрэг нийцлийг хянаж, мөрдсөний дагуу явууллаа. Мөн цаашлаад компанийн дотоодын ажилтнуудаас бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалт, маркетинг, зар сурталчилгаа, хөдөлмөрийн харилцаа, гэсэн хэсэгт хуваан судалгааг авсан бөгөөд үүн дээр үндэслэн зөрчил илрүүлэх, сайжруулах процессын зөвлөмжийг тодорхойллоо.



БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Хэрэглэгчээ чанартай, аюулгүй бүтээгдэхүүнээр тогтмол хангах нь АПУ ХК-ийн тэргүүлэх чиглэл юм. Чанарын баталгаа ба бүтээгдэхүүний аюулгүй байдал нь манай компанийн бизнесийн зарчмуудын нэг бөгөөд чанарын удирдлагын тогтолцоо нь хууль тогтоомж болон зохицуулалтуудын шаардлага, ISO стандарт, дотоод стандартын дагуу хүнсний аюулгүй байдал, чанарын стандартыг дагаж мөрдөх платформ болж байдаг юм.

Бид 2022 онд чанарын удирдлагын тогтолцоогоо шинэчилж чанар, хүнсний аюулгүй байдлын соёлыг бэхжүүлэх, ур чадварыг сайжруулах, төлөвлөгөөт шалгалтуудыг хийх, баталгаажуулалтыг сайжруулах, эрсдлийг урьдчилан таамаглах, илрүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн. АПУ групп компаний хэмжээнд Олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо **ISO 9001**, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо **FSSC 22000** стандартуудын хэрэгжилтийг дэлхийд тэргүүлэгч SGS компаниар амжилттай шалгуулж дахин баталгаажууллаа. Мөн СББ компани анх удаа Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо FSSC 22000 стандартын шаардлагыг бүрэн хангаж олон улсад бүртгэлтэй боллоо.

Хэрэглэгчдийнхээ хүсэл шаардлагыг сонсож, тэдний хүлээлтэнд нийцсэн бүтээгдэхүүнүүд бий болгох нь сайн бизнесийг бий болгох чухал зүйлсийн нэг юм. Үүний дагуу:

- Олон жилийн турш амжилттайгаар үйл ажиллагаагаа явуулж өөрийн гэсэн үнэнч хэрэглэгчдээ бий болгож тэдэнд аюулгүй, өндөр чанартай хүнсийг хүргэх.
- Эрүүл, амт чанартай бүтээгдэхүүнээр орчин үеийн хэрэглэгчдийн хэрэгцээг хангах, зохистой хэрэглээ бүхий амьдралын хэв маягийг бий болгох.
- Байгаль орчинд ээлтэй техник технологийг ашиглан бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх.
- Хэрэглэгчийн хүлээлтийг ойлгож, шинжлэх ухаан, инновацид суурилсан чанартай, шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх.
- Хүнсний тэнцвэртэй хэрэглээг бий болгох зорилгоор хүнсний системээ сайжруулж, сүү сүүн бүтээгдэхүүн болон байгалийн ургамлын хандмал ундаа, эрдэсжүүлсэн шүлтлэг усыг санал болгох.

Хүнсний аюулгүй байдлын стандартын хүрээнд түүхий эдээс бэлэн бүтээгдэхүүн болон хэрэглэгчдэд хүрэх хүнсний бүхий л сүлжээнд мөшгөх тогтолцоог бий болгосон. Энэхүү мөшгөлтийн процессийг Ultimate ERP програм дээр суурилан бүрэн автоматжуулснаар үл тохиролтой бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлсэн тохиолдолд богино хугацаанд үр дүнтэйгээр татан авах боломжийг бий болгосон байна.



“АЮУЛГҮЙ БАЙДАЛ”

HEINEKEN-ийн амь насаа хамгаалах амлалтууд нь манай компанид ажилладаг бүх хүмүүст хамаатай аюулгүй ажиллагааны дүрмүүд юм. Эдгээр нь эрсдэлийг бууруулах хөтөлбөрөөр дэмжигддэг бөгөөд ноцтой, хүний амь нас алдах ослоос урьдчилан сэргийлэх түлхүүр юм.

Үйл ажиллагаа эрхэлдэг бүх компаниуд Амь насаа хамгаалах дүрмийг дагаж мөрдөх ёстой. 2022 онд бид үйлдвэрлэл үйл ажиллагаандаа амь насаа хамгаалах 12 амлалтыг бүрэн мөрдөн ажиллаж байна.

APJ COMPANY
Absoluts Plus Unique

АЮУЛГҮЙ
 АЖИЛЛАГАА
 ҮРГЭЛЖ НЭГТ!

АМЬ НАСАА ХАМГААЛАХ 12 АМЛАЛТ

					
Согтуурах, мансуурахаас зайлсхий	Хүрдээ хоёр гараар барь, жолоодлогод төвлөр	Суудлын бүсээ зүү, хамгаалалтын малгай өмс	Зөвшөөрөгдсөн хурдаар яв	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг аюулгүй ашигла	Засвар, үйлчилгээ хийхдээ Цоож-Пайз ашигла
					
Нүүрсчлийн хийтэй орчинд шаардлагатай арга хэмжээг хангаж ажилла	Аюултай бодистой харьцах үедээ аюулгүй байдлаа ханга	Хязгаарлагдмал орчинд орохдоо зөвшөөрөл ав	Өндөрт ажиллахдаа унахаас сэргийл.	Халуун ажлыг зөвшөөрөл авч хий	Сэрээт ачигч машины аюулгүй байдлыг хангаж ажилла

САИН ТУРШЛАГА

АПУ компанийн үйлдвэрлэл үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нийт ажилтнуудын ихэнх нь замын хөдөлгөөнд тээврийн хэрэгсэл жолоодон байнга оролцдог. Иймд замын хөдөлгөөнд соёлтой оролцох, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор сар бүр хамт олондоо “Аюулгүй ажиллагааны манлайлагч” болсон жолооч нар өөрсдийн туршлага, ур чадвараа хуваалцсан блогийг тогтмол хүргэлээ.

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

САИН ТУРШЛАГА

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг нэмэгдүүлж, аюулгүй жолоодлогын манлайлал, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилготой блогийн энэ сарын зочноор тээвэр түгээлтийн албаны төлөөллүүд уригдсан юм.

Зочдоос маань өгсөн зөвлөмж:

- Хөдөлгөөн эрчимжсэн үед гүйцэж түрүүлэхгүй байх
- Хэт богино зайд ухрах үйлдэл хийхгүй байх
- Замын нөхцөлд тохируулан хурд хэтрүүлэлгүй зорчих
- Эгнээ байрлалыг зөв эзлэн жолоодох
- Хөдөлгөөнтэй автомашинууд хоорондын аюулгүйн зайг барих
- Том оврын тээврийн хэрэгслийн сохор бүсэд нэвтэрч буюу хажууд нь наалдаж явахгүй байх
- Том оврын тээврийн хэрэгслийн эргэлтийн үед давхар эргэж болохгүй.



Та бүхэнд энэхүү блогтой холбоотой санал сэтгэгдэл байвал компанийн ХАБЭА, БО-ны албанд нээлттэй хандвал, талархан хүлээн авах болно.

Танд амжилт хүсье!



Онц тээвэрчин
А.ЭНХБАТ



Тээврийн жолооч
Х.АРИУНБААТАР

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

АПУ ХК нь аюулгүй байдлын шинэ стратегийг 2021 оноос эхлэн компанийн хэмжээнд нэвтрүүлэн хэрэгжүүлж ирсэн. Үүний дагуу учирч болох хамгийн өндөр эрсдэлүүдийг тодорхойлж, хамт олноороо аюулгүй байдлаа хангахад идэвх оролцоотой хандсанаар замын хөдөлгөөний аюулгүй байдал, жолоодлого, гэрээлэгчийн аюулгүй байдал, аюулгүй байдлын манлайлал гэсэн гурван чиглэлд анхааран ажиллаж, түүнд зориулсан олон хөтөлбөрийг компанийн хэмжээнд амжилттай хэрэгжүүллээ. Мөн нийт 18 удаагийн сургалтыг зохион байгуулж, ажлын байран дээрх Эргономикийн зөвлөгөөний гарын авлагыг боловсруулж, Аюулгүй байдлын манлайлагч тэмцээнийг зохион байгуулж, нийт ажилчдад аюулгүй ажиллагааг дагаж мөрдөх давуу тал, осол гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх чадавхыг таниуллаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал

Компанийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын нийт 14 удаагийн ХАБЭА үзлэг, шалгалт аудит хийж, 156 зөрчил илэрснээс 78%-ийг нь засаж залруулсан байна. Мөн МХГ, ОБЕГ-ын 5 удаагийн шалгалтанд амжилттай хамрагдаж, 3440м2 талбайн тэмдэг, 52 ширхэг самбар 1200м урт тууз зэргийг байршуулан жолоодлогын үед гарч болохуйц ослоос сэргийлж ажиллаж байна. Мөн том оврын 78 тээврийн хэрэгсэлд замын хөдөлгөөнийг хянах хар хайрцаг, /Wi-Fi/ ухрах камер байршуулах туршилт хийлээ.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХИЙЛГЭЛЭЭ.

2022 оны тухайд бид АПУ компанийн хэмжээнд гэрээт мэргэжлийн байгууллагаар бүрэн хэмжээний “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ” хийлгэж гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. Мөн эрсдэлийг даатгагч “Хаан даатгал” компанитай хамтын ажиллагааны хүрээнд Англи улсын “Tyser risk management” компанийн гадаад мэргэжилтнүүдээр үйлдвэрлэл, инженерингийн тоног төхөөрөмж, байгууламжуудад эрсдэлийн үнэлгээ хийлгэж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч байна.

“ ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛ



БАЙГУУЛЛАГА БОЛОН АЖИЛТНУУДЫН ЧАДАМЖИЙГ ӨСГӨХ

Ажилтан бүр байгууллагыг бүрдүүлэгч эд эс нь болдог бөгөөд байгууллага нь хүнээс бүрдсэн амьд организм юм. Иймээс ажилтан бол компанийн гол үнэт зүйлс гэж авч үзэн ажилтан бүрт анхаарч ажиллах, аливаа зүйлсийг хамгийн түрүүнд хүн талаас харж тэнцвэртэй, эрх тэгш шийдвэр гаргах нь байгууллагын анхаарвал зохих зүйлсийг нэг юм. Түүнчлэн энэ ойлголт нь АПУ компанийн үнэт зүйлс болон эрхэм зорилгод шингэсэн ба үүнийг бодитоор бий болгоход анхааран Хүн төвтэй засаглалын бодлогыг бий болгосон. Хүн төвт засаглалын бодлогын гол чиглэл нь хүний аз жаргалтай амьдралын 3 хүчин зүйл болох эрүүл, урт удаан амьдрах, хийж буй зүйлдээ дуртай байх, нийгмийн орчинд эрх тэгш бусадтай харилцахаас бүрдэх бөгөөд эдгээрийг байгууллагын орчинд тэнцвэртэй авч явахыг эрмэлзэн хүн рүү чиглэсэн гол хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууддаа шингээн ажиллаж байна.

АПУ ХК нь хүн төвтэй засаглалын бодлогын хүрээнд:

- Байгууллага болон ажилтнуудын чадамжийг өсгөх,
- Байгууллагын соёлыг бэхжүүлж ажиллахад таатай орчныг бий болгох,
- Эрх тэгш, шударга байгууллагыг бий болгоход чиглэн ажиллаж байна.

“АПУ АКАДЕМИ”

“АПУ Академи”-ийн 2025 он хүртэлх стратеги, бодлогын баримт бичгийг боловсруулсан. Энэ хүрээнд компанийн үнэт зүйлс, үзэл баримтлалыг таниулсан сургалт болон хувь хүний хөгжилд чиглэсэн “Багаар ажиллах чадвар”, “Манлайлын чадвар”, “Асуудал шийдвэрлэх чадвар” зэрэг ерөнхий ур чадварын сургалтуудыг дотооддоо амжилттай зохион байгууллаа. “АПУ Академи”-ийн сургагч багш нар нь олон улсын Master trainer хөтөлбөрийн дагуу бэлтгэгдсэн анхны багш нар бөгөөд өөрсдийн санаачилгаар сайн дурын клуб буюу “APU Academy Community and trainers hub” үндэслэн байгуулан сургалтын хүртээмж, агуулгыг улам сайжруулахад анхааран байгууллагын тасралтгүй хөгжлийг бэхжүүлсээр байна.



БИД ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТНУУДЫН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ЧИГ ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ САЙЖРУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТНУУДЫН УР ЧАДВАРЫГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРГЭХ ЗОРИЛГОТойгоор HR DIAMOND COMPETENCY-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.

Хүний нөөцийн стратегийн бизнес партнер
Ц.Хишигжаргал

Ажилтнуудын манлайллын болон мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулснаар байгууллагын чадамжийг нэмэгдүүлдэг тул ажилтан бүрд нээлттэй суралцах орчин болон суралцах соёлыг бий болгох эрхэм зорилготойгоор АПУ Академи сургалт хөгжлийн үйл ажиллагаагаа явуулдаг.



Нийт дотоод сургагч багш

72



Нийт сургалтын цаг

5269



АПУ Академи нь тус чиг үүргийн академиудын дотоод сургагч багш нарыг бэлтгэх хөтөлбөрийг 4 удаа зохион байгуулж нийт 72 Сургагч багшийг амжилттай төгсгөсөн. Чиг үүргийн академиуд тус бүрийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2023 онд ажилтнуудын ур чадварын зөрүүг тодорхойлж үүн дээр суурилсан оновчтой сургалт хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахаар зорьж байна.

FUNCTIONAL ACADEMY

АПУ Академи нь чиглэл, бодлогоо оновчлон 2022 оны турш үндсэн үйл ажиллагааны чиг үүргийн академиудыг бий болгон ажиллаа. Чиг үүргийн академи нь ажилтны мэргэжлийн талын ур чадварыг нэмэгдүүлэх, олон улсын мэдлэг туршлагыг нэвтрүүлэх, ажилтан ажлын байрандаа илүү бүтээмжтэй ажиллахад нөлөөлөх бүхий л ур чадваруудыг цогцоор авч үзэн сургалтын хөтөлбөрөө боловсруулан, ажилтнуудыг тасралтгүй сургахад гол зорилго нь оршдог бөгөөд Үйлдвэрлэл, үйл ажиллагааны академи, Санхүүгийн академи, Хүний нөөцийн академиуд нь сургалт хөгжлийн үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Эдгээр академиудын үйл ажиллагааг тухайн чиглэлийн ажилтнууд өөрсдөө манлайлан ажиллаж бие биедээ суралцах соёлыг бий болгон ажилладаг.

АПУ Академи нь тус чиг үүргийн академиудын дотоод сургагч багш нарыг бэлтгэх хөтөлбөрийг 4 удаа зохион байгуулж нийт 72 Сургагч багшийг амжилттай төгсгөсөн. Чиг үүргийн академиуд тус бүрийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2023 онд ажилтнуудын ур чадварын зөрүүг тодорхойлж үүн дээр суурилсан оновчтой сургалт хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахаар зорьж байна.



FINANCE ACADEMY



Санхүүгийн мэргэжлийн сургалт

40



Санхүүгийн бус ажилтнуудад зориулсан сургалт

14



HR ACADEMY



Хүний нөөцийн олон улсын сургалт

11



Нийт сургалтын цаг

110



Суралцах соёл бий болгох чөлөөт уулзалт

10

АПУ “МЕНТОРШИП ХӨТӨЛБӨР”-2022

АПУ ХК нь шинэ залуу ажилтнуудад карьер төлөвлөлт, хувь хүний хөгжил болоод мэргэжлийн зөвлөгөө, менторинг болон көүчинг үйлчилгээг ажлын байрнаасаа авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Менторшип Хөтөлбөр”-ийг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.



2022 оны “Менторшип хөтөлбөр”-ийн хувьд тасралтгүй суралцах соёлыг түгээх хувь хүний авьяас, ур чадварыг таньж илрүүлэх, хөгжүүлэх замаар багийн болоод тухайн хувь хүний гүйцэтгэлийг нэмэгдүүлэх үндсэн гурван зорилготойгоор 2021 оны 12 сарын 8-ны өдөр албан ёсоор нээлтээ хийж, хөтөлбөрийн оролцогчид нийт 8 сарын хугацаанд PwC Академийн зүгээс зохион байгуулсан төрөл бүрийн сургалтанд хамрагдахын зэрэгцээ удирдах багийн гишүүдээс бүрдсэн Менторуудынхаа мэдлэг, туршлагаас давхар суралцаж, ийнхүү амжилттай төгслөө.

“Менторшип Хөтөлбөр”-ийн 2022 оны оролцогчид нь нийт 4 багт хуваагдаж, компанид түгээмэл тохиолдож болохуйц тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий бичил төслүүдийг нийт 3 сарын хугацаанд хэрэгжүүлж, үр дүнгээ танилцуулан шилдэг төслөө шалгарууллаа.



ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ НЭГЖ

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ БЭХЖҮҮЛЖ, АЖИЛЛАХАД ТААТАЙ ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ



Зорилго:

Ажилтнуудад эмнэлгийн яаралтай болон анхан шатны тусламжийг үзүүлэх, ажлын байрнаас хөндийрүүлэлгүй эмчлэн эрүүлжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх болон амьдралын зөв дадал хэв маяг олгохтой холбоотой нийгэм эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулахад оршино.

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 2022 онд АПУ ХК - ийн хэмжээнд

- Эмчийн үзлэг: 12328
- Сувилахуйн тусламж үйлчилгээ:
Эмийн : 21998 /булчин, судас, дусал, арьсан доорх тариа/
Эмийн бус: 8769 /бариа , бумба , шарлага, физик эмчилгээ/


2. Анхны тусламж :

- Дуудлага – 158
- Осол гэмтэл – 4
- Боолт – 680 /бохир, цэвэр боолт/

3. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ:


- Хүнсний үйлдвэрийн ажилчдын зайлшгүй шинжилгээнд АПУ 2 удаа нийт 755 ажилтан , АПУ ДЭЙРИ 2 удаа 299 ажилтан хамруулж 100% гүйцэтгэлтэй хамруулав.
- Эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 115 эмэгтэй

4. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт:




APU LIFE ХӨТӨЛБӨР

АПУ ХК нь ажилтнуудын ажил амьдралын тэнцвэрт байдлыг хадгалах, ажилтан бүрийн бие болон сэтгэлзүйн эрүүл мэнддээ анхаарах боломжийг олгох, эерэг амьдралын хэв маягийг түгээх, хамтын үнэ цэнтэй мөчүүдийг бий болгох зорилгоор 2022 онд "APU Life" хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүллээ. Энэхүү хөтөлбөр нь дараах 4 чиглэлд төвлөрсөн.



"APU Life" Хөтөлбөрийг доорх 3 төрлөөр хэрэгжүүлэн ажиллах ба Сайн сайхан байдал тус бүр өөрийн холбогдох Дадал, Зөвлөгөө мэдээлэл, Идэвхжүүлэх үйл ажиллагаанаас бүрдэнэ.





СЭТГЭЛ САНАА

Тодорхойлолт

Сэтгэл санааны сайн сайхан байдал нь бидний бодол санаа, мэдрэмж, зан төлөвөө /behavior/ ухамсарлах мэдрэмжийн тухай юм. Энэ нь өөрчлөлт, бэрхшээлийг даван туулах, өөрийн хариу үйлдэлдээ илүү анхааралтай хандаж, эерэг сэтгэлгээг дадлагажуулж, аливаа зүйлд алсын хараатай байж, илүү тайван байдал руу хөрвөх чадвар бөгөөд танд баяр баясгалан, аз жаргалыг бэлэглэх тэр мөчүүдийг мэдрэх явдал юм.

Ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэнд сайн сайхны төлөө бие биенээ халамжлах, сонсох, тулгамдсан асуудлыг нээлттэй хуваалцан хамтдаа шийдвэрлэх, компанийн зүгээс дэмжих зорилготой. Үүний хүрээнд:



Талархлын аян
Талархлын аян зохион байгуулж ажилтнууд бие биедээ болон компанийн зүгээс ажилтны гэр бүлд талархал илэрхийлэн бэлэг илгээсэн.



Тодорхойлолт

Нийгмийн сайн сайхан байдал нь эргэн тойрны хүмүүстэй эерэг харилцааг бий болгон, хадгалахыг хэлнэ. Найз нөхөд, гэр бүл, хамт ажилладаг хүмүүстэй эерэг харилцаатай байх нь стрессийг даван туулахад тусалдаг бөгөөд оюун санаа болон бие махбодын эрүүл мэндийг бүхэлд нь сайжруулдаг.



НИЙГМИЙН ХАРИЛЦАА



Ажилтан хоорондын харилцаа болон нийгэмд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор ажилтнуудыг идэвхжүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулан ажиллав. Үүнээс хамгийн өргөн хүрээнд хийсэн үйл ажиллагаа нь **АПУ фестивал** байсан ба ажилтнуудыг бие биетэйгээ танилцах, хоорондын харилцааг нэмэгдүүлэх зорилгоор 2000 гаруй ажилтан хамрагдсан.



Түүнчлэн АПУ марафонд оролцсон хураамжийг ажилтнуудын санаачилгаар **“Мод бид 2”** төсөлд хандивлан **200 мод** тарьсан.



“Are you okay” аяны хүрээнд ажилтнуудад зөвлөгөө мэдээлэл хүргэж, өглөөний угталт зохион байгуулсан.





БИЕИЙН ЭРҮҮЛ МЭНД

Тодорхойлолт


Бие махбодын сайн сайхан байдал нь бидний бие болоод сэтгэл санааг эрүүл байлгахад тусалдаг ба үүнд эрүүл хооллолт, хангалттай унтах, дасгал хөдөлгөөн хийх багтана. Эдгээр зүйлс нь нь бидний биеийг хүчирхэгжүүлэн энергийг нөхөх ба аз жаргалын мэдрэмжийг нэмэгдүүлдэг.

Ажилтнуудын биеийн эрүүл мэндэд анхааран дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор АПУ компанийн сонирхлын клубүүдтэй хамтарсан үйл ажиллагааг нийт ажилтнуудын хэмжээнд зохион байгуулан ажиллаа. Үүнд:



- АПУ Марафон
- АПУ Олимп
- Иог

Мөн зөвлөгөө мэдээллийг ажилтнуудад тогтмол давтамжтай хүргэв.



Тодорхойлолт

Ажил мэргэжлийн сайн сайхан байдал нь хийж буй ажлынхаа зорилго, утга учрыг ойлгох, бие даан болон хамт олонтойгоо илүү үр дүнтэй хамтран ажиллахыг хэлнэ.

Хийж буй ажлын үнэ цэн, зорилгыг ойлгох, илүү бүтээмжтэй ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд Ажил, мэргэжлийн сайн сайхан байдалд мөн анхааран ажилласан. Үүний хүрээнд



600 орчим ажилтнуудын гэр бүлийг хүлээн авч АПУ компанийн үйлдвэрүүдийн аялал зохион байгуулав.





APU TALK
Компанийн 5 үнэт зүйлсийн хүрээнд хамт олноо манлайлан ажилладаг ажилтнууд түүхээ хуваалцан нээлттэй уулзалт хийлээ.



УЯН ХАТАН АЖЛЫН ЦАГ

АПУ ХК нь замын хөдөлгөөний оргил цагийн ачааллаас зайлсхийн, цаг алдалгүй ажилдаа ирэх, буцах хугацаагаа илүү үр ашигтай байдлаар зохицуулах зорилгоор 2022 оны 4 дүгээр сараас эхлэн “Уян хатан ажлын цаг” - ийн зохицуулалтын сонголтыг бий болгосон. Ингэснээр ажилтнууд ажлын цагт баригдалгүйгээр 7:00 –10:00 цагийн хооронд ажилдаа ирж, 16:00-19:00 цагийн хооронд тарах боломжтой болсон юм.

Нийт ажилтнуудын **20.9%** нь уян хатан цагаар ажиллаж байна.



ХҮҮХДИЙН ӨРӨӨ

Ажилтнууд сургууль цэцэрлэгээс хүүхдээ аваад ажил тартал ажлын байран дээр түр хугацаагаар байлгах хэрэгцээнд тулгуурлан Хүүхдийн өрөөг тохижуулав.

ХӨХҮҮЛ ЭЭЖИЙН БУЛАН

Хөхүүл эхчүүдэд зориулсан жишиг буланг “Mommy’s corner” нэртэйгээр АПУ компанийн нийт **3 байршилд** 2022 онд шинээр байгууллаа.

Ингэснээр компанид ажиллаж буй хөхүүл эхчүүдийн хэрэгцээг хангаж, ажлын байрны таатай орчныг бий болгож байна.

Эхийн сүү саах орчныг бүрдүүлэх, сүүг зохистой хадгалах боломжийг бий болгосноор хүн амын эрүүл мэнд, ирээдүй хойч болсон үр хүүхдийн эрүүл өсөлтөд эергээр нөлөөлсөн ажил болно гэж итгэж байна.





**ӨНДӨР УУЛАНД
АВИРАХ НЬ ХҮНД
АСАР ИХ ТЭСВЭР
ТЭВЧЭЭР, ТАСРАЛТГҮЙ
УРАГШЛАХ ЭРЧ ХҮЧ,
ХАМТРАГЧ НАРТАА
НАЙДАЖ, ХАМТДАА
ДАВАН ТУУЛАХ
ИТГЭЛИЙГ ӨГДӨГ.**

АПУ ХК-ийн Савлалтын үйлдвэрийн дарга
АПУ HIKING CLUB- ийн Ахлагч
Т. Түмэнжаргал

“СОНИРХЛЫН КЛУБ” - ҮҮД

АПУ компани нь ажилтнуудынхаа сонирхол хоббиг дэмжиж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, хамт олны хоорондын уялдаа холбоог сайжруулан, оролцоог нь нэмэгдүүлэх үүднээс анх 2015 онд “Сонирхлын клуб”-үүдийг байгуулсан. Энэхүү сонирхлын клубүүд нь “АПУ HIKING, АПУ PHOTOSHOOTING, АПУ MUSIC, АПУ COOKING” зэрэг 13 спортын төрлөөр байгуулагдсан бөгөөд ажилтан бүрд өөрийн сонирхлын дагуух клубт хамрагдаж, хоббигоо хөгжүүлэх боломжийг олгож буйгаараа давуу юм.




ЭРХ ТЭГШ, ШУДАРГА БАЙГУУЛЛАГЫГ БИЙ БОЛГОХ НЬ

АПУ компанид нийт 40 хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажилладаг ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх тэгш хүртээмжтэй ажлын орчинг бий болгох зорилгоор 2022 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллав.

1. Хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод дүрэм журам, нэрийн хуудсуудыг Брайл хэвлэлд хөрвүүлэн, дохионы хэлтэй сургалт видеог бэлтгэв.

2. JICA DPUB “Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд Job Coach бэлтгэх сургалтад хамрагдсан. Хүний нөөцийн мэргэжилтнүүд мөн мэргэшсэн дохионы хэлмэрчийн сургалтад хамрагдлаа.

3. Явган хүний замын тэмдэглэгээ, автомашины зогсоол, шатаар зөөвөрлөгчийг байршуулан ажлын байрны тохируулгыг хийв.



АПУ компани “ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ХҮРТЭЭМЖТЭЙ
ОНЫ ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГА” - аар шалгарлаа.





“Тогтвортой маргаашийн төлөөх тэгш, хүртээмжтэй өнөөдрийг бүтээх нь”



НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Байгууллагаас 2022 оны уриалга болгон гаргаж буй **“Тогтвортой маргаашийн төлөөх”** санаачилгад нэгдэн албан ёсны зөвшөөрөлтэйгөөр энэхүү арга хэмжээг зохион байгуулж хэрхэн олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж, компанийн нийгэм, олон нийт төдийгүй хүний нөөцийн бодлогын зорилтуудаа хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлэх талаар хэлэлцлээ. Энэ үеэр АПУ ХК-ийн Захиргаа, хүний нөөц эрхэлсэн захирал Ж.Ичинхорлоо цаашид компанидаа хэрэгжүүлэхээр зорьж буй нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүйн эрүүл мэнд, бие бялдрын эрүүл мэнд тэргүүтэй хүн төвтэй менежментийн бодлогын чиглэлийг танилцуулсан ба компанийн хэмжээнд эмэгтэйчүүдийн манлайллаар хүрэх олон эерэг өөрчлөлт, хөгжлийн боломж байгааг чухалчиллаа.

Мөн арга хэмжээний үеэр эмэгтэйчүүдийн дуу хоолойг илэрхийлэх гүүр болсон клуб болох “The Circle” Sustainability Club нээлтээ хийсэн нь онцлог байв.



БИДНИЙ ТУУЛСАН ЗАМНАЛ



Хүмүүс шоолох л байх,
би гэхдээ машинтайгаа
яг л хүн шиг ярьж,
**“Сайн цэнэглэгдэж,
сайхан амарсан уу”**
гэж өглөөний ажлаа
эхлүүлдэг.

Би өглөө бүр 5:30-д сэрээд, 7:10 цаг гэхэд ажил дээрээ ирчихсэн байдаг. Уг нь ажил маань 8:30 цагт эхэлдэг ч эрт очиж өөрийгөө бэлдэх, аюулгүй ажиллагаагаа сахих, хамгийн гол нь машинтайгаа мэндлэх чухал “ажилтай”. Хүмүүс шоолох л байх, би гэхдээ машинтайгаа яг л хүн шиг ярьж, “Сайн цэнэглэгдэж, сайхан амарсан уу” гэж өглөөний ажлаа эхлүүлдэг (инээв). Яагаад гэвэл машин маань намайг ирэхэд асаж, намайг явахад сая нэг амарна. Өдрийн турш үргэлж хамт байдаг, үнэнч анд минь шүү дээ. Машин бид хоёр түүхий эд, материал хүлээн авахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүнийг түгээлтэд хүргэн ачдаг болохоор үйлдвэрлэлийн эхлэл цэгээс эцсийн цэг хүртэлх гол ажлыг нугалдаг. Ингээд бодохоор хариуцлагатай, үнэ цэнтэй сайхан ажил. Хүмүүст ажлынхаа тухай хэлэхээр бүгд л гайхаж хүлээж авна. Эхлээд сэрээт ачигч машин гэж юу болох тухай, дараа нь эмэгтэй хүн ийм ажлыг гардаж хийдэг гэж үү дээ гэсэн гайхсан асуултад нь хариулах хэрэг гардаг.

АПУ ХК-ийн Сэрээт ачигчийн жолооч **М.Мөнх-Эрдэнэ**



Хүн сэтгэлээсээ, ажлыг гололгүй хийж хамт олонтой, ажилтай байх шиг сайхан зүйл байхгүй шүү дээ.

“АПУ ХК-ийнхаа ажилтнуудад ажиллах таатай, цэвэр орчныг бүрдүүлэн ажилладаг. Хүн сэтгэлээсээ, ажлыг гололгүй хийж хамт олонтой, ажилтай байх шиг сайхан зүйл байхгүй шүү дээ. Манайх надаас гадна талбайн хоёр үйлчлэгчтэй. Тэд нар маань ажилд ороод 2, 3 жил болж байна. Анх цэвэрлэгээний багаж, тоног төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах вэ зэрэг зүйлс дээр зөвлөдөг байлаа. Одоо бол бүгд ажилдаа гаршсан. Бид талбайгаа хуваарилж аваад л цэвэрлэгээгээ хийчихнэ. Хамт олон маань намайг Тэдди ах гэдэг юм. Манайхан өглөө ажилдаа ирээд хамгийн түрүүнд мэндэлдэг хүн нь би ч байж мэднэ. Тэдди ах гээд манайхан намайг андахгүй ээ. Миний хийж байгаа ажлыг хүндэлж, миний насыг ч хүндэлдэг эерэг сайхан хамт олон дунд цаг хугацаа мөн ч хурдан өнгөрчээ. Би тэднээсээ урам, хүндлэл хүртдэг юм.”

АПУ ХК-ийн Цэцэрлэгч **Х. Тэрбиш**



Үйлдвэрийн өндөр гэрлүүдийг солихоор угсармал урт шатан дээр гарах үед сандрах, өөрөө өндрөөс айдаг болохоор эвгүй санагдах үе байсан ч гэлээ “БИ ЭМЭГТЭЙ ХҮН” гэж бусдыг гуйхгүй, харин би инженер хүн, энэ миний хийх ёстой зүйл гэж өөрийгөө зоригжуулдаг байсан.

Ажлын ярилцлагын дараа хариу гартал 21 хоносон. Харин ажилд орох болоход “Бид чамтай эмэгтэй инженер гэж харьцахгүй. Инженер хүмүүстээ тавьдаг тэр л шаардлагыг тавьж ажиллана. Амжилт хүсье!” гэсэн товчхон яриа болж байсан юм. Үнэхээр ч өнөөдрийг хүртэл ажиллахдаа хүйсийн давуу, сул тал ажилд маань гараагүй. Үйлдвэрийн өндөр гэрлүүдийг солихоор угсармал урт шатан дээр гарах үед сандрах, өөрөө өндрөөс айдаг болохоор эвгүй санагдах үе байсан ч гэлээ “би эмэгтэй хүн” гэж бусдыг гуйхгүй, харин би инженер хүн, энэ миний хийх ёстой зүйл гэж өөрийгөө зоригжуулдаг байсан. Анх цахилгаан автоматын техникчээр ажилд орж байсан бол одоо Инженеринг менежер болж дэвшсэн байна.”

TIGER Шар айргийн үйлдвэрийн Инженеринг менежер **Ө.Оюунбаяр**



APU COMPANY

Absolute. Pure. Unique.

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот - 17040, Чингисийн өргөн чөлөө - 14,

Утас: +976 - 7600 2220, Факс: +976 - 11 - 343063

www.apu.mn